

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	31
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	БОДЬ ДААТГАЛ ХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	ГАДААДАД ЗОРЧИГЧДЫН АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНДИЙН BODI+SOS ДААТГАЛ					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай		2021.03.31		ТУЗ/2107	
6	Цахимаар борлуулах эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм		<input type="checkbox"/> Үгүй			
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Балсан		Баярмагнай			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Монгол улсаас гадаадын улс оронд аялагчийн амь нас, эрүүл мэнд					
	Даатгалын үндсэн эрсдэл	1. Олон улсын SOS-ын яаралтай түргэн тусламжийн үйлчилгээ – \$1,000,000 хүртэл 2. Гэнэтийн осол 3. Гэнэтийн өвчлөл*					
	Даатгалын нэмэлт эрсдэл	1. Нислэг хойшлогдох 2. Ачаа тээш хоцрох 3. Хувийн хариуцлага алдах					
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	Гадаадад зорчигчдын BODI+SOS даатгалын хураамжийн дагуу тооцно.					

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ

1. Урьд өмнө мэдэгдэж байсан өвчин, түүний үр дагавараас гарсан зардал, гэнэтийн өвчлөлийн шинж тэмдэг бүхий өвчлөл нь урьд өмнө нь мэдэгдэж байсан өвчний үр дагавар, илрэл, гэрээний “нэр томъёоны тайлбар” гэсэн хэсгийн 1-д зааснаас бусад гэнэтийн өвчлөлөөс үүссэн зардалд нөхөн төлбөр олгохгүй.
2. Даатгалын хүчин төгөлдөр хугацаанд даатгуулагчийг эрүүл мэндийн ноцтой 1 удаагийн тохиолдлын улмаас нэгээс дээш удаа хамгийн ойр байгаа эмнэлэгт түргэн шуурхай хүргэх юмуу эх оронд нь буцаахад гарсан зардал;
3. Олон улсын СОС-д урьдчилан мэдэгдээгүй, зохион байгуулаагүй эсвэл Олон улсын СОС хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд эмнэлгийн болон аяллын тусламж үйлчилгээнд тусгагдсан зардлууд;
4. Гэрээнд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Монгол улсын газар нутагт байх хугацаанд гарсан үйл явдал;

5. Эмчийн зөвлөгөөг үл хэрэгсэн гадаад улс орон руу явах, өмнө тохиолдсон өвчлөл болон урьд өмнө мэдэгдэж байсан нөхцөл, үр дагаварын улмаас эмнэлэг эмчилгээний шугамаар явсан тохиолдолд гарсан зардлууд;
6. Даатгуулагчийн эрүүл мэндийн байдал ноцтой бус бол Олон улсын СОС-ын саналаар тухайн улс оронд эмчлүүлж болох эсвэл Монгол руугаа ирэх хүртэл эмчилгээг хойшлуулж болох тохиолдолд хамгийн ойр байгаа эмнэлэгт хүргүүлэх болон зөөн тээвэрлүүлэхтэй холбогдон гарсан аливаа зардал;
7. Олон улсын СОС даатгуулагчийг хамгийн ойр байгаа эмнэлэгт хүргэх эсвэл зөөн тээвэрлэх шаардлагагүйгээр цаашид аялж болно гэж үзсэн тохиолдолд эмнэлэгт хүргэх эсвэл зөөн тээвэрлэхтэй холбогдон гарсан зардлууд;
8. Жирэмслэлт, төрөлт, дутуу төрөлт, зулбалт болон тэдгээрээс гарах хүндрэлүүд, түүний үр дагавараас гарсан зардал;
9. Мэргэжлийн спорт уралдаан тэмцээнд оролцох эсвэл ивээн тэтгэсэн уралдаан тэмцээнд оролцсон, уул хаданд авирах, хөл бөмбөг, агаарт шумбалт хийх, шүхрээр буух, морь унах, циркийн болон түүнтэй адилтгах тоглолтонд оролцох, скет/ролликоор гулсах, цас мөсний бүх төрлийн спорт, тэдгээрийн уралдаан тэмцээнд оролцох, төрөл бүрийн гүйлтийн уралдаан тэмцээнд оролцох, амьсгалах аппарат зүүн усанд шумбах зэргээс үүдэлтэй зардлууд;
10. Сэтгэл санааны гүн хямрал, цочрол болон сэтгэл мэдрэлийн өвчлөлөөс үүдэн гарсан зардал;
11. Мансууруулах бодис буюу спиртийн төрлийн бүтээгдэхүүн хэтрүүлэн хэрэглэх, амиа хорлох, өөрийгөө санаатайгаар бэртээснээс үүдсэн зардал;
12. Бэлгийн замын халдварт өвчин, түүний үр дагавар, ДОХ болон түүнтэй холбогдон гарах үр дагаварын улмаас гарсан зардал;
13. Тусгай зөвшөөрөлтэй авиа компанийн нислэгээр зорчихтой холбогдон гарсан зардлаас бусад ямарваа нэгэн агаарын нислэгтэй холбогдон Даатгуулагчийн гаргасан зардлууд;
14. Даатгуулагч хууль бус үйл ажиллагаа болон гэмт хэрэг үйлдэхийг завдах эсвэл хийхтэй холбогдон гарсан зардал;
15. Тухайн эмчилгээ нь тухайн улсын стандартын дагуу бус, мэргэжлийн бус эсвэл эмчлэх эрхгүй эмчийн заавар, зөвлөмжийн дагуу хийлгэсэн аливаа эмчилгээтэй холбогдон гарсан зардлууд, гэнэтийн ослын болон өвчлөлийн улмаас хийсэн анхны мэс ажилбарын дараах хүндрэл, анхны мэс ажилбарын дараа дахин хийсэн мэс ажилбар болон түүнтэй холбоотой бусад зардал;
16. Олон нийтийн цуглаан, хүчирхийллийн хөдөлгөөн, болон цагдаа болон цэргийн хүчний хөдөлгөөн, дайнд /зарласан болон зарлаагүй/ оролцох, булаан эзлэх түрэмгийлэл эсвэл гадны халдлагад өртөх, дайны үйл ажиллагаа, иргэний дайн, эсэргүүцэл эсвэл үймээнд самуунд оролцсоны улмаас гарах зардлууд;
17. Цөмийн зэвсэг болон радио идэвхит цацрагийн идэвхжил, химийн бодис эсвэл биологийн материаллаг зүйлсийн шууд нөлөөнөөс үүссэн зардал;
18. Даатгалын хүчин төгөлдөр хугацаанд 65 нас хүрсэн ба түүнээс дээш настай даатгуулагчийн гаргасан аливаа зардал;
19. Ямарваа нэгэн хөлөг онгоц, нефтийн орд газар юмуу үүнтэй ижил төстэй далай дээрх үйл ажиллагаанаас үүдсэн аливаа зардал;
20. Хэвийн эрүүл шүдний эмчилгээ, хиймэл шүд, шүд авах;
21. Сонсгол шалгуулах, сонсголын аппарат тавиулах, чих цоолуулах, шивээс хийлгэх болон тэдгээрээс гарах дагаварууд;
22. Урьдчилан сэргийлэх нүдний үзлэг, хараа шалгуулах, ойрын болон холын харааг засах эмчилгээ, нүдний шил, линз, контактны линз тохируулах;
23. Гэрээнд хамаарагдахгүй аливаа эрсдлийн үр дагаварын улмаас үүссэн хохирол эсвэл нотлох баримтгүй хохирол;
24. Даатгалын хугацаа дууссан, цуцлагдсан үед гарсан зардлууд;
25. Ачаа тээш алдагдсан тохиолдолд даатгагч дараах зүйлүүд эвдэрч гэмтсэн эсвэл алдагдсан бол нөхөн төлөхгүй.
 1. Амьтад, автомашин болон автомашины тоног төхөөрөмж;
 2. Завь эсвэл бусад тээврийн хэрэгсэл, чиргүүл эсвэл мотор;
 3. Мотоцикл, унадаг дугуй (Тээвэрлэгч Байгууллагаас ачаа тээш гэж шалгагдсанаас бусад), нүдний шил, нарны шил болон контакт линз, хиймэл шүд болон холбоос шүд, бусад;
 4. Сонсголын аппарат, хиймэл эрхтэн, түлхүүр, санхүүгийн тамга, үнэт цаас болон бичиг баримт эсвэл зорчигчийн билет;
26. Дараах эд зүйлсээ алдсанаас гарах хохирол:
 - Бэлэн мөнгө, банк эсвэл бэлэн мөнгөний баримт, чек болон гэрээ хэлцэл;
 - Олон нийтийн хяналтгүй газар эсвэл тээврийн хэрэгсэлд орхисон эсвэл анхаарал болгоомжгүй

байснаас алдсан аливаа хөрөнгө/эд зүйлс;

27. Аялал жуулчлалын агентлаг, гэрээт ажилтан, орон сууц ба агаарын тээвэрлэгч болон машин түрээсийн агент болон түүнтэй хамтран ажилладаг байгууллага санхүүгийн хүндрэлд орсон эсвэл төлбөрийн чадваргүй болсон, эсвэл урьдчилсан захиалгыг хийхдээ алдаа гаргасан эсвэл буруутай үйлдэл хийсэн байгууллага, компани, хувь хүн нь төлбөрийн чадваргүй болсон, эсвэл паспорт болон аяллын бичиг баримт, визээ гаргуулж чадаагүй эсвэл захиалгаас хоцрох буюу түүнтэй холбогдон гарах зардлууд
28. Даатгуулагч засгийн газрын олон нийгэд хандсан мэдээлэл болон эрх бүхий албан газрын сэрэмжлүүлгийг үл тоомсорлосноос үүсэх дараах тохиолдлуудад нэхэмжлэл үүсвэл:
 - Тухайн улс оронд зорчихыг хориглосон;
 - Ажил хаялт, эсэргүүцэл, цаг агаарын таагүй байдал, иргэний хөдөлгөөн болон халдварт өвчний дэгдэлт;
 - H1N1 зэрэг агаар дуслаар халдварлах өвчнүүд;
29. Гаалийн ажилтан болон бусад эрх бүхий албан тушаалтнуудын тавьсан хорио цээр, баривчилгаа болон хойшлуулалт;
30. Монголд буцаж ирсний дараа бий болсон ачаа тээшний саатлаас үүссэн зардал;
31. Ковид-19 өвчлөлийн үед гэрээнд хамрагдаагүй өдрийн эмчилгээ (хэвтэн эмчлүүлэх эмчилгээ), амбулаторийн эмчилгээний зардлыг төлөхгүй.